



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2015 оны 05 сарын 20 өдөр

Дугаар А/30

Ховд

┌ Авто машин хэрэглэх журам батлах тухай ┐

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1.4 дэх заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1."Нэг цонхны үйлчилгээ"-ний авто машин хэрэглэх журмыг хавсралтаар баталсугай.


2.Журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Д.Дэлгэрбаяр, Нийтлэг үйлчилгээний албаны дарга Б.Жаргал нарт үүрэг болгосугай.

ДАРГА



Б.БАТМӨНХ

Аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын
2015 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн
А/30 дугаар тушаалын хавсралт



**“НЭГ ЦОНХНЫ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ”-НИЙ
АВТО МАШИН ХЭРЭГЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын “Нэг цонхны үйлчилгээ”-гээр төрийн үйлчилгээ үзүүлдэг Улсын бүртгэлийн хэлтэс, Нийгмийн халамж үйлчилгээний хэлтэс, Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Хөдөлмөрийн хэлтэс нь Нэг цонхны үйлчилгээний УАЗ-Пургон авто машинаар иргэдэд төрийн үйлчилгээг нэг дор, түргэн шуурхай, нээлттэй, ил тод байх нөхцлийг бүрдүүлэн, хүртээмжтэй үйлчилгээг үзүүлэх үйл ажиллагааг зохицуулна.

1.2. Нэг цонхны үйлчилгээний УАЗ-Пургон авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллага нь энэ журмын дагуу авто машин захиалан хэрэглэнэ.

Хоёр. Авто машин хэрэглэх

2.1. Авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллага авто машин хэрэглэх захиалгаа аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны даргад албан бичгээр ажлын 7 хоногийн өмнө мэдэгдэнэ.

2.2. Нэг цонхны үйлчилгээний УАЗ-Пургон авто машины ашиглалтын талаар бүртгэлийн дэвтэр хөтөлж, авто машиныг бусад байгууллагад шилжүүлэхийг хориглоно.

2.3. Нэг цонхны үйлчилгээний УАЗ-Пургон авто машиныг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны жолооч хариуцан үйлчлүүлэгчийн тээвэрлэлтийн нөхцөл, техникийн стандарт үзүүлэлт шаардлагыг хангасан тав тухтай аюул осол саадгүй, соёлч шуурхай үйлчилнэ.

2.3. Авто машин хэрэглэгч байгууллага авто машины шатахууны зардал болон аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийтлэг үйлчилгээний албаны жолоочийн томилолтыг тухай бүр хариуцаж, байгууллагынхаа жилийн төсөвт тусгана.

2.4 Жолоочийн болон автомашины үйлчилгээний чанарын талаарх санал гомдлыг хүлээн авна.

2.5. Авто машинд суурилуулсан техник хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг авто машин хэрэглэгч байгууллага хариуцна.

2.6.Авто машины засвар үйлчилгээг цаг тухайд нь хийж, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, эвдрэл гэмтэлийг авто машин хэрэглэх эрх бүхий албан тушаалтан, байгууллага, жолооч хариуцна.

Гурав. Хариуцлага

3.1.Авто машин хэрэглэх албан тушаалтан, байгууллагын буруутай үйлдлээс болж авто машинд үүссэн эвдрэл гэмтлийн зардлыг тухайн байгууллага, албан тушаалтан хариуцана.